

НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 11 дүгээр сарын 27

2025 оны 11 дүгээр сарын 27																			Улаанбаатар хот	
Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөрийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023 он	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он		Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь		
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19		
ГУРАВ ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО																				
Салбарын үр дүн: Хотын эдийн засгийн суурийг бэхжүүлж, төсвийн бус эх үүсвэрээр хөрөнгө оруулалтыг бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.																				
Зорилтын үр дүн: 3.4 Улаанбаатар хотын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.																				
476			1	Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	2025-2028		724.0					724.0	Шинээр байгуулсан мэдээлэл сурталчилгааны төв, тоо	8	8	194.0	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле" зэрэг нийт 7 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж байна. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд жуулчид хамгийн ихээр зорчдог байршлын судалгааг гаргасан. Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр Жуулчны гудамжийг тохижуулах төсөл, арга хэмжээтэй уялдуулан Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг шинээр тухайн байршилд байгуулахаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлж, бэлтгэлийг ханган ажиллаж байна.	90		
477			2	"Улаанбаатар өвлийн наадам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		627.0					627.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	8000	13000	177.0	Өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадагй болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодтой хамтран "Улаанбаатарын өвлийн наадам-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд "Скай резорт" цанын бавад зохион байгуулна. Арга хэмжээний үеэр Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шайгийн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параллелийнгийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снеубордын хотын аварга шалгаруулах, Уулын цанын хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн хотын аварга шалгаруулах тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгураас нийт 36, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1222 нийт 1258 тамирчин оролцоо. "Улаанбаатарын өвлийн наадам-2025" арга хэмжээг гадаад, дотоодын 13000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100		
478			3	"Улаанбаатар" явган алхалтын фестиваль зохион байгуулна.	2025-2028		507.5					507.5	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	200	1150	112.5	1.Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Монголын явган алхалтын холбоо", "Монгол Олле" нийгэмлэгтэй хамтран "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулна. Фестивальд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улс, БН Казахстан Улс зэрэг 5 улсаас 56 алхагч, "Монголын явган алхалтын холбоо"-ны салбар холбоод, нийслэлийн дүүргүүд, Дорнод, Өмнөговь, Дорноговь, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв зэрэг 11 явган алхалтын клубүүдийн 600 гаруй алхагчид оролцоо. 2.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор "Чингис-21" mountain resort, "Монгол Олле" байгууллагатай хамтран "Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль-2025" арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Налайх дүүргийн 6 дугаар хороо, Горхи Тэрэжийн байгалийн цогцолбор газарт зохион байгуулна. Фестивальд БНСУ-ын Сөүл, Вонжу, Чажу хот, ОХУ-ын Горны Алтай, Эрхүү, Улаан-Үд, Владивосток хот, АНУ, Англи, БНХАУ, БНТажикстан Улс, Филиппин, БНЧех Улс, Тайвань, ХБНГерман Улс, Бутаны хаант улс зэрэг 10 улсын төлөөлөл, Монголын явган алхалтын холбоо, клубүүдийн 500 гаруй явган аялагч, алхагчид оролцсон. Арга хэмжээний өдрүүдэд оролцогчдын дунд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, сээр цохих наадаан, дэмбээ наадаан, шайн наадагй, морь, тэмээ унах, галын наадам, бий биелгээ, өвхөр хатирах, од дурандах, задгай кино үзвэрээс гадна Улаанбаатар театрын уран бүтээлчид урлагийн тоглолт, "Хаадын хаан Чингис хаан" морьтны тусгай шоу үзүүлбэр зэрэг олон арга хэмжээг зохион байгуулна.	100		

484	3.4.1.Жуулчдад зориулсан болон сонирхлын хуулчдад зориулсан болон сонирхлын хэмжээнүүдийг тогтмол байгуулж шинэ үйлчилгээг бий болгоно.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ	9	"Улаанбаатар травел" экспо зохион байгуулна.	2025-2028		117.0						117.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	3000	2500	27.0	Аялагчид дотооддоо болон гадаад улс руу мэргэжлийн байгууллагаар дамжуулан аяллаа төлөвлөх, аяллын хөтөлбөр, багцуудтай танилцах, захиалгаа хямдралтай үнээр өгөх болон аялал жуулчлалын байгууллагууд, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг нэг дороос хүртээмжтэй байдлаар авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран "Улаанбаатар травел экспо 2025" аялал жуулчлалын үзэсгэлэнг 11 дэх жилдээ 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын "Их танхимд" зохион байгуулнаа Үзэсгэлэнд БНХАУ-ын Хайнань мужийн "Visit Atlantis Sanya" байгууллага, ӨМӨЗО-ны CITS (China International Travel Service) аялал жуулчлалын тур оператор компани, Монгол Улсаас Өмнөговь, Ховд, Дархан, Дорноговь, Архангай зэрэг 5 аймаг болон 90 гаруй аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид аяллын дагалдах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулан оролцож, үзэсгэлэнг гадаад, дотоодын нийт 5000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
485			10	"Талын салхи" олон улсын мото наадамьг зохион байгуулна.	2025-2028		700.0						700.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	5000	7000	250.0	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын чопперчин ахан дүүс ТББ-тай хамтран "Талын салхи-2025" олон улсын мото наадмыг 10 дахь жилдээ 2024 оны 06 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон "Хүй долоон хутаг"-т зохион байгуулнаа. Мото фестивальд оролцогчид Энхтайваны өргөн чөлөө буюу Сүхбаатарын талбай-Улсын их дэлгүүр-Баруун дөрвөн зам-Таван шар-61-н гарам-Хүй долоон хутагт гэсэн маршрутгаар 50 км мото парад зохион байгуулж, арга хэмжээнд БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ, Малайз, Вьетнам зэрэг улсуудаас 300 гаруй, Монгол Улсаас Улаанбаатар хот болон 21 аймгийн 45 гаруй клубийн 2500 гаруй нийт 2800 гаруй мотоцикл сонирхогчид оролцов. Арга хэмжээний үеэр оролцогчдын дунд гар барилдах, туг сүлжих, мото удаан явах зэрэг тэмцээн уралдаан болон мото түүний дагалдах хэрэгслийн үзэсгэлэн, гэр, майхан кемпийн үйлчилгээ, хоол, ундааны үйлчилгээ болон мото үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100
486			11	"Даншиг наадам-Иргэдийн баяр" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		10,300.0						10,300.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо		15000	2,500.0	Монголчуудын уламжлалт өв соёлыг таниулан сурталчлах, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ас заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам" арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Хүй долоон худагийн "Монгол наадам цогцолбор"-т зохион байгуулнаа. Арга хэмжээний үеэр цам харайх ёслол, "Очирваань" бурхны тахилга, сор залах ёслол, соёмбот туг залах ёслол үйлдэх, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг үнзэд голч нарын тэмцээн болон Үндэсний хүчит 256 бөхийн барилдаан, 6 насны хурдан морины уралдаан, жороо морьдын уралдаан, морьт харвааны тэмцээн, сээр шалгах тэмцээн, "Урхай" шалгайн харвааны тойром, үндэсний сур харвааны тэмцээн тус тус зохион байгуулнаа. Арга хэмжээг гадаад, дотоодын нийт 30000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
487			12	"Плэйтийм" олон улсын амьд хөгжмийн наадамьг зохион байгуулна.	2025-2028		80.0						80.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	30000	55000	20.0	Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Амьд хөгжмийн наадам" ТББ хамтран "Плэйтийм-2025" олон улсын хөгжмийн наадамь 23 дахь жилдээ 2025 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр "Тайж хайрхны бэл"-д зохион байгуулнаа. Азийн тэргүүлэх хөгжмийн фестиваль болох зорилготой "Плэйтийм-2025" олон улсын хөгжмийн наадамд гадаадын 20 улсын 40 хамтлагийн 150 уран бүтээлчид, Монгол Улсаас 300 гаруй хамтлаг дунд нийт 450 гаруй хамтлаг, уран бүтээлчид 4 өдрийн турш 12 тайзнаас уран бүтээлээ хүргэж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 94436 хүн үзэж сонирхсон.	100


488	13	"Дээлтэй Монгол наадам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	400.0	400.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	10000	12000	100.0	Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Аддын хувьсгалын 104 жилийн ой, Үндэсний их баяр наадмын хөтөлбөрийн хүрээнд Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, ад хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Улсын хүүхэд залуучуудын театр, Монголын Аялал жуулчлалын холбоо, "Монгол костюмс" төв хамтран "Дээлтэй Монгол наадам"-ыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр ханжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулна. "Дээлтэй Монгол наадам"-ын баярын жагсаалд БНХАУ-ын ӨМӨЗО-оос 50 гаруй Монгол турратны төлөөлөл, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон "Бяцхан мисс Олон улсын хүүхдийн байгууллага", "Аидра академ", "Монголын Үндэсний уламжлалт уран хатгамалчдын холбоо", "Монгол Оршихуйн Ухаан" зэрэг 10 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 7000 гаруй хүн оролцоно. Арга хэмжээнд оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг дээл урлаач, гадаадын шилдэг эргэтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 12 номинациар шилдгүүдийг тодруулж, арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, Монгол дээлийн үндсэн загварыг орчин үеийн хэв маягтай хослуулан загварчилсан үзүүлбэр, АХА асуулт хариултын тэмцээн зэрэг арга хэмжээ болон 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 48 иргэн, аж ахуй нэгж, байгууллага үндэсний дээл хувцас, ад хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10000 гаруй хүн үзэж сонирхсон.	83.3
489	14	"Даншиг наадам-Хүрээ цам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	3,330.0	3,330.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	1000	1000	780.0	Монгол улсыг гадаад улс оронд сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор Монгол номадич жуулчны баазтай хамтран "Даншиг босгогч наадам" арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгуулна. Арга хэмжээний үеэр цагаан идээ боловсруулах, ноос савах, эсгий урлал хийх, үхэр, тэмээн тэргээр нүүдэл хийх болон, Шувуулахуй /Махчин анги шувуудын үзэсгэлэн, үзүүлбэр/, Монгол банкрын хүрээ, үндэсний урлагийн тоглолт, үндэсний бөх, сур харваа, шагайн харваа, морьт харваа, хурдан морины уралдаан, цам харайх үзүүлбэр зохион байгуулж арга хэмжээг 1000 гаруй аялагч, жуулчид үзэж сонирхно.	100
490	15	"Хийморь" морьт харвааны олон улсын тэмцээн арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	400.0	400.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	5000	7000	80.0	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүнийг бий болгох, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Азийн Морьт Харвааны Холбоо", "Монголын Морьт Харваачдын Холбоо" болон "Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолбортой хамтран "Хийморь" азийн аварга шалгаруулах олон улсын морьт харвааны тэмцээнийг 2025 оны 08 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулна. Тэмцээнд Монгол, АНУ, Австрали, БНХАУ, БНСУ, БНТУ, Франц, Унгар, Румын, Малайз, Япон, Зимбабве, БАЕНУ, ОХУ-ын Бүгд Найрамдах Саха Улс (Якут) зэрэг 18 улсын 60 гаруй тамирчид оролцоно. "Хийморь" азийн аварга шалгаруулах олон улсын морьт харвааны тэмцээнийг "Ази харваа", "Унгар харваа", "Турк харваа", "Бөмбөг" намина болон багийн гэсэн 5 төрлөөр зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 8000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
491	16	"Улаанбаатар" олон улсын фото зургийн фестиваль зохион байгуулна.	2025-2028	80.0	80.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо				"Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам" 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, арга хэмжээний үеэр "Богдын хүрээ ба Улаанбаатар" түүхэн фото зургийн үзэсгэлэн мөн Нийслэл хотын түүхэн дурсгалт барилгуудын леги үзмэрүүд болон Судлаач, уран бүтээлч С.Чулуунбаатарын түүхэн судалгаанд тулгуурлан VIII Богд Жавзандамбын амьдралтай холбоотой онцгой цуглуулгуудыг тодоор сэргээн баринтагласан 12 ширхэг усан будгийн уран зургийн бүтээлүүдийг олон нийтэд дэлгэн үзүүлж, үзэсгэлэнг 1000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
492	17	"Ай Тм Эм" олон улсын аялал жуулчлалын зохион үзэсгэлэнг байгуулна.	2025-2028	90.0	90.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	3000	4000	21.0	Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран "ITM Mongolia-2025" (International Travel Mart) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 26 дахь жилдээ "Тогтвортой аялал жуулчлал-Хариуцлагатай аялагч" уриан дор 2025 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд "Мишээл экспо" төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулна. Үзэсгэлэнд 19 аймгийн тур оператор компани, амралтын газар, жуулчны бааз, ресторан, зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч болон урлаг, соёлын 300 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцож, үзэсгэлэнг гадаад, дотоодын нийт 8000 гаруй хүн үзэж сонирхсон.	100

493			18	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейг сэргээгдэх эрчим хүчээр хангах барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	2025-2028		3,200.0						3,200.0	Барилга, угсралтын ажлын явц хувь	70	100	200.0	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/253 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн зураг төсвийн ажил 160,000,000 (нэг зуун жаран сая)-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэж байгууллагаар "Аркоос" ХХК шалгарч зургийг гүйцэтгэж батлуулав. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/717 дугаар захирамжаар Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын цахилгааны эх үүсвэр, тохижилтын ажлын 40,000,000 (дөчин сая) худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэж байгууллагаар "Филипс гэрэлтүүлэг" ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж, хүлээн авах Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ажилласан.	100
494	3.4.2. Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ	1	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгана.	2025-2028								Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тоо	15	20		Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран "Go Winter - Өвлийн хямдралтай аян"-ыг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хуртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлнэ.	100	
											Хамрагдсан байгууллага, тоо	69	80		"Go Winter - Өвлийн хямдралтай аян"-ыг 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.	100			
495	3.4.3. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.		1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулна.	2025-2028								Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгчид, тоо	488	500		Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан 20 өвөнт арга хэмжээ, үзэсгэлэнгийн үеэр түр ажлын байр бий болгож 751 жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдааг гаргаж 14,579,681,400 төгрөгийн борлуулт хийсэн. Мөн Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатарын соёлын өдрүүд" арга хэмжээний хүрээнд жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.	100	
496		2	Жуулчдад зориулсан төрөлжсөн худалдаа үйлчилгээний гудамж, хэсгийг бий болгоно.	2025-2028		2,400.0						Тохижуулсан гудамж байршлын тоо					Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж, явуулын үйлчилгээг бий болгох, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний гудамж, хэсэг байгуулах 5 газрын судалгааг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран гаргасан.	50	
497	3.4.4. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилна.	1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчилна.	2025-2028		580.0						Эй Ар Би Ар (AR VR) дэвшилтэд технологиор бүтээсэн контент, тоо		2	100.0	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета нүсэр 3S төрлийн 11 ширхэг Би Ар (VR) төхөөрөмжийг худалдан авч, 8 арга хэмжээ, 13 үзвэр, үйлчилгээний газар, 6 дурсгалт газар нийт 27 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн.	100		

498	3.4.5.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.	1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчилна.	2025-2028	2,150.0						Оролцсон олон улсын үзэсгэлэн, тоо	4	9	400.0	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 9 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож Улаанбаатар хотыг сурталчилсан. Үүнд: ХБНГУ-ын Берлин хотноо 2025 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бүс болох Хонгконг хотноо 2025 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны (WTCF) ээлжит чуулга уулзалт арга хэмжээ, БНХАУ-ын Бээжин хотноо 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "COTTM-2025" (China Outbound Travel & Tourism Market) олон улсын үзэсгэлэн, Улаанбаатар хотноо 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатар travel expo 2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "SITF 2025-Seoul International Travel Fair" олон улсын үзэсгэлэн, БНСУ-ын Бусан хотноо 2025 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Дэлхийн Хотуудын Аялал Жуулчлалын дээд хэмжээний уулзалт", Япон улсын Токио хотноо 2025 оны 09 дүгээр сарын 25-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Tourism Expo Japan - 2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Жэжү мужад 2025 оны 11-р сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Жэжү Олле" явган алхалтын фестиваль, БНХАУ-ын Ханиань мужийн Саньяа хотноо 2025 оны 11 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, номхон далайн аялал жуулчлалын холбооноос зохион байгуулсан арга хэмжээ	100
499	3.4.6.Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч, нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилна.		1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад цахим орчинд нөлөө бүхий инфлюенсрээр дамжуулан сурталчилна.	2025-2028	650.0						Олон улсад Социал орчинд нөлөө бүхий инфлюенсрээр сурталчилсан сурталчилгаа, тоо	2	4	130.0	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор "Бүргэдийн баяр-2025" арга хэмжээний үеэр Аяллын тойрог нэвтрүүлэг, "УБ Фүүд фестиваль-Узбек улсын хоолны өдөрлөг" арга хэмжээний үеэр социал орчинд нөлөө бүхий 2 инфлюенсрээр, Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатарын соёлын өдрүүд" арга хэмжээг Унгар улсын 5 инфлюенсрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 2,250,000 хүнд хүргэсэн.	100
Хэрэгжилтийн дундаж хувь 96.36																	

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА  Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  М.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  В.М. ОМОН-ОТГОН